

**ЗАЛИЛАНГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ, ШАЛГАХ ДҮРЭМ**

**Боловсруулсан:** Овог, нэр: Гарын үсэг, огноо:  
 Байгууллагын нэгж, хэсэг: Катя Срака  
 Санхүүгийн Хэлтэс Марьета Пирц  
 Хууль, Эрх Зүйн Хэлтэс Барбка Рус Крумбергер  
**Баталсан:**

---

**Байгууллагын нэгж, хэсэг:** Овог, нэр: Гарын үсэг, огноо:  
 Дүрэм Журмын Хэрэгжилт  
 Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэн Давид Братож  
 Хууль Зүйн Хэлтэс Борут Лекше

**Баталсан:**  
 Удирдах Зөвлөл: Огноо:

72/2018 тоот тогтоолын дагуу 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр КРКА, д.д. Ново место компанийн 4 дүгээр ээлжит хуралдаанаар батлав.

**Хүчин төгөлдөр болсон огноо: 2018 оны 5 дугаар сарын 1**

<i>Өмнөх хэвлэлийн хяналт</i>	
<i>Хэвлэл</i>	<i>Оруулсан өөрчлөлт</i>
Удирдах Зөвлөлийн Тогтоол № 72/2018	2015 оны <i>Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах дүрэм</i> ба 2015 оны <i>Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах бодлогыг</i> хүчингүй болгож 2018 оны шинэ <i>Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах дүрмийг</i> батлав.
Удирдах Зөвлөлийн Тогтоол № 259/2015	2015.12.7-ны <i>Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах дүрэм</i> 2015.12.7-ны <i>Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах бодлого</i>

## АГУУЛГА

I	Зорилго .....	3
II	Цар хүрээ ба хэрэглээ .....	3
III	Шудрага бус байдал болон залиланг хориглох нь .....	4
IV	Залилангийн менежментийн хяналт .....	4
V	Залилангийн менежментийн журам, авах арга хэмжээ .....	6
VI	Залилангийн сэжигтэй үйлдлүүдийг мэдээллэх нь .....	6
VII	Ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх журам .....	7
VIII	Шилжилтийн болон эцсийн нөхцлүүд .....	7

## I Зорилго

Энэхүү *Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах дүрэм* (цаашид “Дүрэм” гэх) нь КРКА, д.д. Ново место болон түүний харьяа байгууллагуудад (цаашид “Крка” гэх) залилангаас хамгаалахтай холбоотой үндсэн зорилго, зарчим, дүрэм журмыг тодорхойлно. Мөн энэхүү журам нь залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгахтай холбоотой Крка-гийн ажилтнуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилготой.

Энэхүү *Журам* нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, зөвлөмж болон Крка-гийн ёс зүй, бизнесийн үйл ажиллагаа, ёс суртахууны хэм хэмжээний зарчмыг тодорхойлдог **Крка-гийн Ёс зүйн Дүрэмд** үндэслэсэн болно.

Крка нь Залилангийн менежментийн асуудлаар дараах зорилготой ажиллана. Үүнд:

- Үл тэвчих (zero tolerance) зарчимд тулгуурлан залилангийн эрсдэлийг бууруулах
- Учирч болох залилан болон залилангийн менежментийн талаарх ажилчдын ухамсрыг нэмэгдүүлэх
- Залилангийн эрсдэлийг илрүүлэх болон түүнийг мэдээллэх тухай ажилчдын үүрэг хариуцлагатай холбогдуулан ажилчдад сургалт олгож, дадлагажуулах
- Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэхтэй холбоотой дотоод хяналтын системээ цаг үргэлж сайжруулж, удирдан зохицуулах
- Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах тогтвортой эх сурвалжаар хангах
- Холбогдох дүрэм журам, удирдамж, хууль тогтоомжийг цаг ямагт мөрдөж ажиллах
- Сэжиглэгдэж буй залилангийн асуудалд тухай бүрт анхаарал хандуулж, зүй ёсоор шалгах
- Мэдээллэгчийн нэрийг нууцлах
- Крка-гийн нэр хүнд, эд хөрөнгийг хамгаалах.

## II Цар хүрээ ба хэрэглээ

Энэхүү *Дүрэм* нь Крка-гийн бүх ажилтнуудад хамаарах бөгөөд Крка болон бусад хуулийн этгээд, хувь хүн (цаашид “гуравдагч этгээд”)-тэй холбоотой аливаа үйлдэл хийх үед даган мөрдөгдөх ёстой.

Крка-гийн аливаа ажилтан болон гуравдагч этгээд нь сэжиглэгдэж буй залилангийн тухай мэдээлэл өгөхдөө энэхүү *Дүрмийг* баримтална.

Энэхүү *Дүрэм* нь залилан, авлигалын эсрэг олон улсад мөрдөгдөж буй дүрэм, журам болон Крка-гийн дотоод удирдамжтай нийцэж байгаа бөгөөд ажилтнууд өөрсдийн үүрэгт ажил болон Крка-гийн бизнесийн үйл ажиллагааг явуулахдаа энэхүү дүрмийг чандлан мөрдөх ёстой.

Крка-гийн харьяа байгууллагууд энэхүү *Дүрмийн* заалтуудыг даган мөрдөж, тухайн улсынхаа шаардлагад нийцүүлэн дотоод дүрэм журмыг баталж ажиллах үүрэгтэй.

Бүх ажилтнууд eCampus цахим сургалтын систем эсвэл өөр зохих аргыг ашиглан энэхүү *Дүрмийн* агуулгатай танилцсан байх ёстой. Ажилтнуудад дээрх байдлаар *Дүрэмд* орсон өөрчлөлтүүдийг

мэдээллэнэ. Шинэ ажилтан ажлаа хүлээн авахдаа мөн адил энэхүү *Дүрмийн* агуулгатай танилцах ёстой.

### III Шудрага бус үйлдэл болон залиланг хориглох нь

Энэхүү дүрмэнд бүх төрлийн шудрага бус үйлдэл, залиланг хориглоно. Нэн ялангуяа үүнд дараах асуудлууд хамаарна.

- **Авлига**, энэ нь хувьдаа болон аливаа гуравдагч этгээдэд ашиг хонжоо олохын тулд албан тушаалаа урвуулан ашиглах явдал юм. Давуу байдлыг амласан эсвэл ёс суртахууныг зөрчихийг урамшуулсан эсвэл давуу байдлыг зохих ёсоор төлөх төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн үйлдэл нь авлигын зорилготой байх магадлалтай.
- **Залилан** бол Крка эсвэл аливаа гуравдагч этгээдэд хор хөнөөл учруулан хууль бус буюу шударга бус аргаар ашиг олох зорилготой ёс зүйгүй, хууль бус үйлдэл юм. Жишээлбэл залиланд хууран мэхлэх, нөхцөл байдлыг нуун дарагдуулах, итгэлийг буруугаар ашиглах, санхүүгийн тайланг худал мэдүүлэх гэх мэт үйлдлүүд орно. Хувь хүмүүс эсвэл компаниуд хууль бус аргаар мөнгө буюу эд хөрөнгийн хэлбэрээр материаллаг ашиг олох, эсвэл өөрсдийн ашиг сонирхлоосоо болоод хууль бус аргаар Крка болон гуравдагч этгээдэд хор хөнөөл учруулахуйц үйлдэл хийсэн бол залилан үйлдсэн гэж үзнэ. Хувь хүмүүс болон компаниуд залилан мэхлэх замаар өөрсдийн үүрэг хариуцлага, үйлчилгээний алдагдлыг шийдвэрлэх эсвэл хувийн болон бизнесийн давуу байдлаа хамгаалах гэж оролдох магадлалтай.
- **Хээл хахууль**, энэ нь аливаа хууль бус, ёс зүйгүй үйлдэл хийсний төлөө эсвэл итгэлийг зөрчсөний урамшуулал болгон аливаа давуу тал олгохыг хүсэх, хүлээн авах, амлах, санал болгох, өгөх, өдөөн хатгахыг хэлнэ.
- **Ашиг сонирхлын зөрчилдөөн**, энэ нь авлигал эсвэл бусад хууль бус үйлдлүүдэд хүргэх үйл ажиллагааг явуулах буюу өдөөх нөхцөл байдлыг хэлнэ. Ашиг сонирхлын зөрчилдөөнд хүн ажил үүрэг албан тушаалын шаардлага болон хувийн ашиг сонирхлын хоорондын сонголттой тулгардаг.

### IV Залилангийн менежментийн хяналт

Залилангийн менежментийн хяналтын арга хэмжээнүүдийг Крка-гийн зохион байгуулалтын түвшин бүрт хэрэгжүүлнэ. Чанар, ил тод байдал, аюулгүй байдал, гүйцэтгэлийг хангахын тулд эдгээр арга хэмжээнүүдийг боловсруулсан. Эдгээр арга хэмжээнүүд нь гадаад дотоод журам, стандарт, бизнесийн сайн дадал, дүрэм, бичиг баримт баталгаажуулах систем, ажилтнуудын эрх мэдэл, үүрэг хариуцлага зэрэгт суурилдаг. Хяналтын арга хэмжээнүүд нь залилангаас урьдчилан сэргийлэх, залилангийн тухай мэдээллэх ажилтнуудын үүрэг, ухамсрын түвшинг нэмэгдүүлэх, залиланг илрүүлж, шалгах зорилготой.

Крка нь стратегийн болон үйл ажиллагааны гол эрсдлүүдийг удирдан зохицуулах, Крка-гийн *Хөгжлийн Стратеги* Болон *Чанарын Гарын Авлагад* тодорхойлсон зорилтуудыг биелүүлэхэд нөлөөлж болохуйц хүчин зүйлсийг цаг тухайд нь таньж тогтоох, удирдан зохицуулах боломж олгодог хяналтын орчинг бий болгосон. Бие даасан хяналтын үйл ажиллагаа нь залилангийн менежменттэй холбоотой.

Крка-гийн *Эрсдэлийн бүртгэлд* учирч болох бүх эрсдлүүдийн дэлгэрэнгүй танилцуулга байдаг. Крка нь эрсдэлийн менежментийг бизнесийн бүх үйл ажиллагаандаа нэгтгэн тусгасан байдаг. Бид хяналтын арга хэмжээ, бизнесийн үйл ажиллагааг тасалдалгүй явуулах үүрэг хариуцлага, эрсдэл бууруулах асуудлуудыг тодорхойлсон маш олон стандарт үйл ажиллагааны журам, дотоод удирдамж зааварчилгааг ашиглаж байна.

Байгууллагын удирдлагын түвшинд залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгахтай холбоотой үүрэг хариуцлагыг доор дэлгэрэнгүй дүрслэв.

КРКА, д.д. Ново место компанийн **Удирдах Зөвлөл** нь компанийн хөрөнгийн хэмжээ, нэр алдрыг хадгалахын тулд тохиромжтой хяналтын орчныг бүтээх нөхцлөөр хангадаг. Удирдах Зөвлөл нь залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах асуудлыг хариуцсан Дүрэм журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэнг томилдог.

**Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэн** дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Залилангийн эрсдэлийг үнэлж дүгнэх
- Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах дотоод хяналтын системийг санал болгох
- Мэдээлсэн сэжиглэгдэж буй залилан бүрийг зүй ёсоор шийдвэрлэж, мэдээлэгчийг хамгаалах
- Энэхүү *Журмын* агуулгын талаар ажилтнуудад мэдээллэх, сургалт боловсрол олгох, ухамсрын түвшинг нь нэмэгдүүлэх
- Сэжиглэгдэж буй залилангийн асуудалтай холбоотой мэдээлэл, бичиг баримтуудыг бүртгэж, тэмдэглэл хөтлөх
- Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгахтай холбогдуулан Удирдах Зөвлөлд тайлан тавих
- Гадны мэргэжилтнүүд, хууль сахиулах байгууллагуудтай хамтарч ажиллах.

**Хэлтэс, алба, бие даасан нэгжүүдийн дарга нар** нь дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Эрх мэдлийнхээ хүрээнд тухайн бүс нутаг дахь залилангийн эрсдлийг үнэлж дүгнэх
- Залиланг хянах зохицуулах үр дүнтэй дотоод хяналтын системийг хэрэгжүүлэх
- Аливаа хэлбэрийн залилангийн эсрэг үл тэвчих (zero tolerance) зарчмыг баримтлах
- Сэжиглэгдэж буй залилангийн асуудал нь тухайн нэгж, хэлтэст хамаарч байвал **Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэнтэй** хамтарч зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

**Ажилтан тус бүр** дараах үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Крка-гийн *Дүрэм* болон бусад бүх холбогдох дүрэм журмын дагуу үнэнч шударгаар ажиллах

- Залилангийн шинжтэй аливаа үйлдэл, хэлцлийг мэдээллэх
- Залилангийн шинжтэй аливаа нотлох баримтыг хадгалан, хамгаалах
- Аливаа хэлбэрийн залилангийн эсрэг үл тэвчих (zero tolerance) зарчмыг баримтлах.

## V Залилангийн менежментийн журам, авах арга хэмжээ

Залилангийн менежментийн журам, авах арга хэмжээ нь залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах гэсэн гурван шатнаас бүрдэнэ. Голдуу залилангаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төвлөрнө. Гэхдээ залиланг илрүүлэх ажиллагаа чухал бөгөөд сэжиглэгдэж буй томоохон залилангийн асуудлыг мэргэшсэн мэргэжилтэнүүд болон холбогдох байгууллагын шүүн таслах эрх мэдлийн хүрээнд шалгуулна.

Залилангийн менежментийн тогтмол үйл ажиллагаанд дотоод журам, зааварчилгааг баталж, нэмэлт өөрчлөлт оруулах замаар залилангийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ орно.

Крка нь ашиг сонирхлын зөрчлийн менежментийг байгууллагын үйл ажиллагааны стандарт журам болон эрсдэлийг бууруулж, Крка-гийн нэр хүндийг унагааж мэдэх ашиг сонирхлын зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлдэг дүрэм журамд нийцүүлэн явуулдаг.

Крка нь эрүүл мэндийн салбартай холбоотой бүх харилцааг холбогдох дүрэм журам, зааварчилгааны дагуу явуулж, хууль бус үйл ажиллагаа явагдах боломж нөхцлүүдийг бууруулж буй эсэхийг баталгаажуулдаг. Харьяа байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа дүрэм журмын дагуу явуулж, бүтээгдэхүүнийг сурталчлахад зохих ёсоор бэлтгэгдсэн байна.

Залилангийн менежментийг амжилттай хэрэгжүүлэхэд ажилтнуудын боловсрол, сургалт чухал нөлөөтэй. Крка-гийн сургалтын хөтөлбөр, дотоодоо хэвлэгдсэн мэдэгдэл, мэдээллийн самбар нь ажилтнуудад учирч болох залилан, залилангийн шинжтэй үйл ажиллагаануудын талаар хангалттай хэмжээний мэдээлэл өгдөг.

## VI Залилангийн сэжигтэй үйлдлүүдийг мэдээллэх нь

Крка-гийн аль нэг ажилтан эсвэл гуравдагч этгээд нь залилангийн сэжигтэй үйлдлийг мэдээллэх боломжтой.

Крка-гийн ажилтан нь залилангийн шинжтэй аливаа үйлдлийг илрүүлвэл дээд албан тушаалтандаа мэдэгдэх ёстой. Залилангийн шинжтэй үйлдлийн онцлог шинж, нөхцөл байдлаас үүдэн мэдээллэх боломжгүй бол үүнийг Хууль Эрх Зүйн Хэлтэс Эсвэл Эрсдэлийн Удирдлага Дүрэм Журмын Хэрэгжилтийн Хэлтсийн Дарга, Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэнд мэдээллэнэ. Мөн залилангийн шинжтэй үйлдлийг нэрээ нууцалж мэдээллэх боломжтой. Залилангийн шинжтэй үйлдлийг мэдээллэх цахим шуудан: [compliance.officer@krka.biz](mailto:compliance.officer@krka.biz).

Залилангийн шинжтэй үйлдлийг мэдээллэгч нь нэрээ нууцлахыг хүсэхгүй бол дараах утсаар залгаж мэдээллэх боломжтой.

- Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэн: +386 7 331 78 18;
- Хууль Эрх Зүйн Хэлтсийн Дарга: +386 7 331 95 95;
- Эрсдэлийн Удирдлага Дүрэм Журмын Хэрэгжилтийн Хэлтэс: +386 7 331 93 93.

Крка нь мэдээлэл өгсөн хүний хувийн мэдээллийг мэргэжлийн үүднээс чандлан нууцалж, түүнийг аливаа хариу арга хэмжээнээс хамгаалах үүрэгтэй.

## **VII Ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх журам**

Хууль Эрх Зүйн Хэлтэстэй хамтран Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэн нь ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх тусгай баг бүрдүүлж болно. Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэнгээс гадна тус баг нь байгууллагын өөр өөр нэгжид ажилладаг, сэжиглэгдэж буй залилангийн шинжтэй үйлдлүүдийг шалгах чадвар бүхий хоёроос дөрвөн ажилтнаас бүрдэнэ. Энэхүү баг нь мэдээлсэн сэжиг бүхий залилангийн үйлдлүүдийг зохих ёсоор шийдвэрлэж, учир шалтгааныг нь тогтоож, засаж залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Залиланг шалгах ажлыг тусгай чадвар бүхий ажилтан, шаардлагатай бол гадны мэргэжилтнүүд, хууль сахиулах албаныхнаар шалгуулна.

Хорон санаа агуулаагүй, итгэл үнэмшилтэйгээр сэжиг бүхий залилангийн үйлдлийн тухай мэдээллэж буй ажилтныг хариу арга хэмжээнээс хамгаалж, зохих тусламж дэмжлэгийг үзүүлж, мэдээллийн үр дүнг мэдэгдэнэ. Мэдээллэгчийн хувийн мэдээллийг чандлан нууцална. Аливаа хариу арга хэмжээг Крка-гийн *Дүрмийг* ноцтой зөрчсөн гэж үнэ.

Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэн нь ирүүлсэн мэдээлэл, түүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн тухай тэмдэглэл хөтлөх ёстой.

Шалтгалтын үр дүнд үндэслэн Дүрэм Журмын Хэрэгжилт Хариуцсан Ерөнхий Мэргэжилтэн нь Удирдах Зөвлөлд дараах хувилбаруудын аль нэгийг мэдэгдэнэ. Үүнд:

- Сэжиглэгдэж буй залилангийн тухай мэдээлэл олдоогүй бөгөөд цаашид шалгалт хийх шаардлагагүй;
- Сэжиглэгдэж буй залилангийн тухай мэдээлэл олдсон бөгөөд шийтгэл оногдуулах, хяналтын журмыг сайжруулах гэх мэт дотоод арга хэмжээ авах шаардлагатай;
- Сэжиглэгдэж буй залилангийн тухай мэдээлэл олдсон бөгөөд зохих ур чадваруудыг эзэмшсэн ажилтан эсвэл гадны мэргэжилтэн, хууль сахиулах албан тушаалтнаар цаашдын шалтгалтыг гүйцэтгүүлэх шаардлагатай.

Сэжиглэгдэж буй залиланг дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгана.

## **VIII Шилжилтийн болон эцсийн нөхцлүүд**

Компанийн Удирдах Зөвлөл нь энэхүү *Дүрмийг* батална. Дүрмийг Крка-гийн дотоод вэбсайт (Krkonet) болон Крка-гийн олон нийтийн вэбсайт дээр нийтэлнэ.

Энэхүү *Дүрэм* буюу *Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах дүрэм* хүчин төгөлдөр болсон өдөр 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн *Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах дүрэм* болон 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн *Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах бодлого* хүчингүй болно.

Энэхүү *Дүрмийг* хоёр жилд нэг удаа хянан үзэж, шаардлагатай бол өөрчлөлт оруулах ёстой.